



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/134/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn  
Ахлах аудитор А.Даваадорж  
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит"  
ХХК-ийн захирал С.Должинсүрэн  
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Улаанбаатар хот  
2022 он

## АГУУЛГА

---

2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3.	Аудитын тайлан.....	11
3.1.	Ерөнхий зүйл.....	11
3.2.	Байгууллагын зорилго, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3.	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4.	Материаллаг байдал.....	12
3.5.	Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7.	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8.	Аудитын гол асуудал.....	14
3.9.	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10.	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11.	Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4.	Аудитын илрүүлэлт.....	15
4.1.	Залруулсан алдаа.....	15
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТЗҮЭГ	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.24 № 07/326

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол төрийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>83,697,621.25</b>	<b>25,309,606.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>475,640.00</b>	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	475,640.00	-
31110	Төгрөг	475,640.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>7,445,721.00</b>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	7,445,721.00	-
<b>3351</b>	<b>Байгууллагаас авах авлага</b>	7,445,721.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>21,636,965.57</b>	-
34200	Төсөвт байгууллага	21,636,965.57	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>54,139,294.68</b>	<b>25,309,606.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>54,139,294.68</b>	<b>25,309,606.00</b>
35410	Бичиг хэргийн материал	5,886,492.00	-
35420	Аж ахуйн материал	30,847,415.68	5,877,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,688,470.00	4,384,250.00
35440	Түлш, шатах тослох материал	109,575.00	239.00
35450	Барилгын засварын материал	-	4,936,745.00
35470	Бусад хангамжийн материал	13,607,342.00	10,110,572.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>520,037,560.12</b>	<b>519,366,544.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>520,037,560.12</b>	<b>519,366,544.00</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>520,037,560.12</b>	<b>519,366,544.00</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,500,000.00)	(6,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	62,695,224.75	72,886,724.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,594,669.51)	(52,366,126.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,174,560.00	68,174,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,650,980.22)	(67,752,153.18)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	484,716,160.80	484,716,160.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,787,507.30	140,787,507.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(132,844,339.00)	(135,834,225.55)
39217	Ном	8,754,096.00	8,754,096.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Программ хангамж	41,776,640.00	41,776,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(41,776,640.00)	(41,776,640.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>603,735,181.37</b>	<b>544,676,150.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>603,735,181.37</b>	<b>544,676,150.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>603,735,181.37</b>	<b>544,676,150.00</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	742,060,566.40	742,060,566.40
51101	Өмч: - төрийн	742,060,566.40	742,060,566.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(142,601,651.43)</b>	<b>(201,660,682.80)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(156,652,095.68)	(148,799,051.43)
51220	Тайлант үеийн үр дүн	14,050,444.25	(52,861,631.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,276,266.40	4,276,266.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>603,735,181.37</b>	<b>544,676,150.00</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,492,100.00	304,821,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>299,441,655.75</b>	<b>357,683,531.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>299,441,655.75</b>	<b>357,683,531.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>269,787,457.85</b>	<b>314,464,741.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>195,106,407.65</b>	<b>191,074,694.32</b>
210101	Үндсэн цалин	195,106,407.65	191,074,694.32
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,364,841.77</b>	<b>24,832,582.03</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,364,841.77	24,832,582.03
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,335,059.94</b>	<b>52,092,838.68</b>
210401	Бичиг хэрэг	2,540,977.00	6,805,492.00
210402	Тээвэр шатахуун	9,164,139.00	7,375,839.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	938,466.62	1,267,800.00
210404	Ном, хэвлэл	-	59,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,990,000.00	4,012,422.00
210408	Бараа материал акалсны зардал	9,701,477.32	32,571,785.68
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>7,771,750.00</b>
210604	Урсгал зардал	-	7,771,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>1,089,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	1,089,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,172,470.43</b>	<b>16,313,068.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	55,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	12,127,602.43	13,243,700.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,044,868.00	1,014,368.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,808,678.06</b>	<b>21,290,607.79</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,708,810.00	8,228,091.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	9,099,868.06	10,862,516.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,654,197.90</b>	<b>43,218,789.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,600,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,654,197.90</b>	<b>41,618,789.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,654,197.90	41,618,789.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>14,050,444.25</b>	<b>(52,861,631.37)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,050,444.25</b>	<b>(52,861,631.37)</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>(156,652,095.68)</b>	<b>589,684,737.12</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	14,050,444.25	<b>14,050,444.25</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>(142,601,651.43)</b>	<b>603,735,181.37</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,197,400.00)	<b>(6,197,400.00)</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>(148,799,051.43)</b>	<b>597,537,781.37</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(52,861,631.37)	<b>(52,861,631.37)</b>
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>(201,660,682.80)</b>	<b>544,676,150.00</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>313,492,100.00</b>	<b>304,821,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,492,100.00	304,821,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>313,492,100.00</b>	<b>305,297,540.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>297,579,262.00</b>	<b>295,106,040.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>267,925,064.10</b>	<b>251,887,250.02</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>194,708,927.17</b>	<b>191,074,696.82</b>
210101	Үндсэн цалин	138,898,725.17	140,997,814.57
210102	Нэмэгдэл	44,108,394.00	36,276,387.40
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	11,701,808.00	13,800,494.85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,523,180.31</b>	<b>24,832,579.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,523,180.31	24,832,579.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,960,626.62</b>	<b>8,954,282.00</b>
210401	Бичиг хэрэг	1,020,000.00	978,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,412,460.00	6,018,182.00



210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,328,166.62	838,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,119,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,420,000.00</b>	<b>2,190,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,420,000.00	2,190,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,915,600.00</b>	<b>11,231,275.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,795,600.00	0.00
210604	Урсгал засвар	13,120,000.00	11,231,275.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>1,089,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	1,089,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,574,900.00</b>	<b>7,225,703.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	55,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	12,000,000.00	5,616,303.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	584,900.00	554,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,821,830.00</b>	<b>5,289,513.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,821,830.00	3,089,513.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,200,00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,654,197.90</b>	<b>43,218,789.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,600,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,	2,000,000.00	1,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,654,197.90</b>	<b>41,618,789.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,654,197.90	41,618,789.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(501,862.00)</b>	<b>(475,640.00)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>16,414,700.00</b>	<b>10,191,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,414,700.00</b>	<b>10,191,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>16,414,700.00</b>	<b>10,191,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,414,700.00	10,191,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(16,414,700.00)</b>	<b>(10,191,500.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(501,862.00)</b>	<b>(475,640.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>977,502.00</b>	<b>475,640.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>475,640.00</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>475,640.00</b>	<b>(475,640.00)</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>304,821,900.00</b>	<b>263,678,750.02</b>	<b>41,143,149.98</b>	<b>86.50</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>304,821,900.00</b>	<b>263,678,750.02</b>	<b>41,143,149.98</b>	<b>86.50</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>303,221,900.00</b>	<b>262,078,750.02</b>	<b>41,143,149.98</b>	<b>86.43</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>210,552,400.00</b>	<b>191,074,696.82</b>	<b>19,477,703.18</b>	<b>90.75</b>
Үндсэн цалин	149,831,400.00	140,997,814.57	8,833,585.43	94.10
Нэмэгдэл цалин	44,854,100.00	36,276,387.40	8,577,712.60	80.88
Унаа хоолны Хөнгөлөлт	15,866,900.00	13,800,494.85	2,066,405.15	86.98
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,424,500.00</b>	<b>24,832,579.53</b>	<b>3,591,920.47</b>	<b>87.36</b>
Тэтгэврийн даатгал	28,424,500.00	24,832,579.53	3,591,920.47	87.36
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,930,700.00</b>	<b>8,954,282.00</b>	<b>1,976,418.00</b>	<b>81.92</b>
Бичиг хэрэг	978,500.00	978,500.00	-	100.00
Тээвэр, шатахуун	7,441,500.00	6,018,182.00	1,423,318.00	80.87
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	838,200.00	838,200.00	-	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	552,500.00	-	552,500.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,120,000.00	1,119,400.00	600.00	99.95
<b>Нормативт зардал</b>	<b>2,191,900.00</b>	<b>2,190,000.00</b>	<b>1,900.00</b>	<b>99.91</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,191,900.00	2,190,000.00	1,900.00	99.91
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,249,600.00</b>	<b>21,422,775.00</b>	<b>4,826,825.00</b>	<b>81.61</b>
Багаж, техник, хэрэгсэл	14,880,000.00	10,191,500.00	4,688,500.00	68.49
Урсгал засвар	11,369,600.00	11,231,275.00	138,325.00	98.78
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,199,000.00</b>	<b>1,089,200.00</b>	<b>109,800.00</b>	<b>90.84</b>
Дотоод албан томилолт	1,199,000.00	1,089,200.00	109,800.00	90.84
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,763,800.00</b>	<b>7,225,703.00</b>	<b>7,538,097.00</b>	<b>48.94</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	55,000.00	935,000.00	5.56
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	12,000,000.00	5,616,303.00	6,383,697.00	46.80
Тээврийн хэрэгслийн татвар	183,800.00	-	183,800.00	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	590,000.00	554,400.00	35,600.00	93.97
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,910,000.00</b>	<b>5,289,513.67</b>	<b>3,620,486.33</b>	<b>59.37</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,410,000.00	3,089,513.67	1,320,486.33	70.06
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	4,500,000.00	2,200,000.00	2,300,000.00	48.89
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,600,000.00</b>	<b>1,600,000.00</b>	-	<b>100.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,600,000.00</b>	<b>1,600,000.00</b>	-	<b>100.00</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>304,821,900.00</b>	<b>263,203,110.02</b>	<b>41,618,789.98</b>	<b>86.35</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,821,900.00	263,203,110.02	41,618,789.98	86.35
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-

<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>18</b>	<b>14</b>	-	<b>77.8</b>
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	11	7	-	63.6
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудиторын туслах П.Амарцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол төрийн түүхийн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Х/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн түүхэнд холбогдох дурсгалыг цуглуулж, хадгалан хамгаалах, судлан шинжлэх, ирээдүйн хойчдоо өвлүүлэн үлдээх, Монгол төрийн түүхэн хөгжил, залгамж шинжийг сурталчлан, нийгмийн ухамсарт нөлөөлж төлөвшүүлэх” гэсэн байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн түүхтэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2021 оны 336 дугаар тогтоол “Музей нэгтгэн зохион байгуулах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус музейн бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт, Дотоод аудитын дүрмийн 4.10, 4.12 заалтын дагуу музейн үйл ажиллагаанд ЗГХЭГ-аас 2 жил тутамд хяналт тавьж ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол төрийн түүхийн музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 299,441.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,988.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,791.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол төрийн түүхийн музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,059.1 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө (касс дахь бэлэн мөнгө)	475.6	-	(475.6)
Авлага	7,445.7	-	(7,445.7)
Урьдчилгаа	21,637.0	-	(21,637.0)
Бараа материал	54,139.3	25,309.6	(28,829.7)
Үндсэн хөрөнгө	520,037.6	519,366.5	(671.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>603,735.2</b>	<b>544,676.1</b>	<b>(59,059.1)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч	603,735.2	544,676.1	(59,059.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн</b>	<b>603,735.2</b>	<b>544,676.1</b>	<b>(59,059.1)</b>

Тайлант онд касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 475.6 мянган төгрөгийг зарцуулж, авлага дансанд бүртгэгдсэн Засгийн газрын автобаазын тооцооны үлдэгдлийн 1,181.0 мянган төгрөгийг барагдуулж, “Оргилсофт” ХХК-тай холбоотой 2007 онд үүссэн, найдваргүй авлагын 6,197.4 мянган төгрөгийг шүүхийн шийдвэр болон холбогдох баримтыг үндэслэн данснаас хассанаар оны эцэст үлдэгдэлгүйгээр тайлагнагдсан.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд музейн үзмэрийн даатгал, засварын ажил, санхүүгийн программын лиценз ашиглалтын төлбөр, 2021 оны хэвлэл захиалгын урьдчилгаа төлбөрийн нийт 21,637.0 мянган төгрөгийг бүртгэснийг тайлант онд холбогдох ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж, зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,309.6 мянган төгрөг болж өмнөх оноос 28,829.7 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, аж ахуйн материалын нөөцөд байсан үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 519,366.5 мянган төгрөг болж 671.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 10,191.5 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдаж авч, элэгдлийн зардалд 10,862.6 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 544,676.1 мянган төгрөг болж 59,059.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралтаас шалтгаалжээ.

Монгол төрийн түүхийн музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,670.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс санхүүжих хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал төлөвлөснөөс 41,143.1 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл цалин, нийгмийн даатгал, музейн үзмэрийн даатгалын зардлууд байна. Энэ нь батлагдсан орон тооноос 4 хүнээр дутуу буюу музейн сан хөмрөгчийг хавсран ажиллуулснаас шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2021 оны төсвийн төслийг 581,740.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 268,460.8 мянган төгрөгөөр бууруулж 313,279.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны төсвийн тодотголоор нийт 304,821.9 мянган төгрөг (үүнд:-хангамж, бараа материалын зардлыг 5,862.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил урсгал засварын зардлыг 5,687.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 7,990.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 400.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж)-өөр баталсан байна.

Энэ нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 304,821.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 263,203.1 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр авч, оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 475.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 263,678.8 мянган төгрөг буюу 86.5 хувиар төсвийг зарцуулж, үлдэгдэл 41,618.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Музей нэгтгэн зохион байгуулах тухай Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 336 дугаар тогтоолоор Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоож, "Чингис хаан" музейд нэгтгэхээр шийдвэрлэсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Аудитаар санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан хийж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол төрийн түүхийн музейн 2021 онд нийт 319,024.2 мянган төгрөгийн 12 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулж, хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.



### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 6,197.4 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулсан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-		-				
Албан шаардлага	2	6,197.4	2	6,197.4			
Зөвлөмж	1	6,500.0	2	6,500.0			
<b>Нийт дүн</b>		<b>12.697.4</b>					

Тус музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй 6,500.0 мянган төгрөгийн өртөг бүхий Мицубиши Делика автомашиныг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын оношилгоо, Баянзүрх техник хяналтын үзлэгийн төвийн дүгнэлтийг гаргуулан актлуулахаар ТӨБЗГ-т ЗГХЭГ-ын 2021 оны ХЭГ/2759 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлсний дагуу ТӨБЗГ-ын даргын 2021 оны А-1/2032 тоот албан бичгээр Засгийн газрын 2021 оны 336 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд судлан шийдвэрлэхээр хариу өгсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,197.4 мянган төгрөгийн алдааг залруулж, зөвлөмж өгөөгүй болно.

### 4.1 Залруулсан алдаа

2007 онд Музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан Оргилсофт ХХК техник хэрэгсэл дутуу нийлүүлсний улмаас үүссэн 6,197.4 мянган төгрөгийн найдваргүй авлагыг шийдвэрлүүлэх талаар өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа зөвлөмж, Албан шаардлага хүргүүлсэн боловч уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй болсон тул дараах нотлох баримтыг үндэслэн 2021 оны санхүүгийн тайланд залруулгын бичилт хийлгэж данснаас хассан. Үүнд:

1. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.03.23-ны 101/ШЗ2016/11990 захирамжаар баримт материалын эх хувь байхгүйгээс шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.
2. ТЗҮЭГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны 316 дугаар албан бичгээр "Оргил софт" ХХК-ийн 2007 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн 08/06 дугаартай гэрээ нь 10 жил хадгалагдаад устгалд орсон болохыг мэдэгдсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Монгол төрийн түүхийн музей	АХГ-2022/134/НА-СТА-ТШЗ	2007 онд үүссэн 6,197.4 мянган төгрөгийн найдваргүй авлагыг шийдвэрлүүлэх талаар өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа, зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн боловч уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй болсон	Аудитаар залруулсан	1	6,197.4	1	6,197.4						
Дүн					1	6,197.4	1	6,197.4						
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
Дүн														
Нийт дүн					1	6,197.4	1	6,197.4						